

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ (ИСС)-ИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЖУРАМ

Хуан Сон Гүнь*

Олон Улсын Эрүүгийн Хэргийн Шүүх (International Criminal Court, товчилсон нэр ИСС)-ийг байгуулахын тулд НҮБ-ын (UN) бүрэн эрхт төлөөлөгч дипломат нарын хуралдаанаас олон талт хэлэлцээр хийх зэргээр уг шүүхийг байгуулах гэрээ 1998.6.15-7.17 өдөр Италийн Ром хотноо ОУ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO) дээр нээгдсэн ОУЭХШ-ийг байгуулах НҮБ-ын бүрэн эрхт төлөөлөгчдийн хурлаас ОУЭХШ-ийн тогтоол (the Rome Statute of the International Criminal Court)-г гаргажээ. Энэ нь олон жилийн турш явагдсан улс хоорондын хэлэлцээр болон Засгийн газрын бус олон нийтийн байгууллага (Non-Governmental Organization, товчилсон нэр NGO)-ын судалгаа, оролцоотойгоор олон улсын хамтын нийгэмлэгийн хүчээр бий болсон бүтээл гэж үзэж болно. Юунаас илүү 1994 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей дээр тавигдсан ОУ-ын хуулийн хороо (International Law Commission, товчилсон нэр ILC)-ны ОУЭХШ байгуулах төсөл (Draft Statute of an International Criminal Court), 1994.5.22-7.22 өдөр хуралдсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн 49 дүгээр хуралдаан дээр оруулсан ОУ-ын хуулийн хорооны 46 дугаар хуралдааны тайлан (Report of the International Law Commission of its Forty-sixth Session) ашиглан (цаашид ОУ-ын хуулийн хорооны төсөл (ILC Draft Statute) товчилсон нэрээр хэрэглэнэ) уг шүүхийг байгуулах үндсэн судалгааны эхлэл болжээ. Түүнээс хойш ОУХХ-ны төслийн талаар дэлхийн олон орны ОУ-ын хуульчид, судлаачид хэлэлцээр хийж, ялангуяа 1995.6 сарын орчим Италийн Сиракус (Siracusa) хотноо болсон ОУЭХШ байгуулах талаархи эрдэм шинжилгээний хуралдаанаас уг төслийн шинэчилсэн төсөл {Draft Statute for an International Criminal Court-Suggested Modifications to the 1994 ILC Draft-prepared by a Committee of Experts for Consideration by the United Nations General Assembly Committee on the Establishment

* МУИС-ийн ХЗС-ийн докторант

of a Permanent International Criminal Court, Second Session, New York, 14-25 August, 1995 цаашид Сиракусын төсөл гэх болно (Siracusa Draft Statute)) хэлэлцэгджээ. Хоёр жил үргэлжилсэн ОУЭХШ байгуулах бэлтгэл хороо (ICC Preparatory Committee, товчилсон нэр ICC prepcom)-ны 5 дугаар хуралдаанаас урьд өмнөх судалгааны үр дүнг нэгтгэх зорилгоор түр хуралдааныг 1998.1.19-30 өдөр Голландын Зюфэн хотод (Zutphen) хуралдаж тухайн үеийг хүртэлх хэлэлцсэн бүх зүйлийг нэгтгэн шинэ төслийг {{цаашид Зюфэний төсөл гэнэ (Zutphen Draft Statute)}} гаргасан ба үүнд тус бэлтгэл хорооны 6 дугаар хурлын хэлэлцээрийн үр дүнг эцэслэн дээрх Ромын дипломат нарын хуралд оруулан дахин судалж үзээд хэлэлцээр байгуулжээ.

I. Олон Улсын Эрүүгийн Хэргийн Шүүх (ICC)-ийн эрүүгийн хуулийн журам

Шүүхийн бүтэц

ОУЭХШ нь шүүгч нараас бүрдсэн шүүхийн дарга нарын хэлтэс, шүүхийн хэлтэс, шүүхийн прокурорыг нийтэд нь хариуцах прокурорын хэлтэс, захиргааны хэлтсийн даргын удирдлагад ажиллах захиргааны хэлтэс гэсэн 4 хэсгээс бүрдэнэ.

Дийлэнх олонхийн саналаар шүүхийн дарга болон 1, 2-р дэд даргаа сонгосон 18 шүүгч бүхий бүрэлдэхүүнтэй ажиллах шүүхийн дарга нарын хэлтэс нь шүүхийн зохистой үйл ажиллагааг захиргааны хувьд нийтэд нь удирдаж, ОУЭХШ-ийн тогтоолын дагуу өгөгдсөн үүргээ гүйцэтгэх бөгөөд шүүхийн хэлтэс нь урьдчилсан шүүх, анхан шатны шүүх, давж заалдсан шүүх ажиллагааны хэсэгт тус тус хуваагдан ажилладаг.

Мөрдөн байцаалт болон хэргийг шалгах үүрэг хүлээсэн прокурорын хэлтсийн тэргүүн прокурор болон туслах тодорхой тооны прокурорыг 9 жилийн хугацаатай томилон ажиллуулах бөгөөд томилолтын хугацаанд прокурорын хэсгийн ажилтан, бусад туслах ажилтан нарыг удирдаж, хэргийн мөрдөн байцаалт, хэргийг шалгах, шүүх, шийдвэр гүйцэтгэх зэрэг ажлыг хийдэг.

Захиргааны хэлтэс нь дарга, дэд дарга, бусад ажилтнаас бүрдэх ба шүүхийн захиргааны ажил албыг шууд хариуцан гүйцэтгэдэг.

Шүүх

ОУЭХШ нь бөөнөөр хомрогolon устгах, хүний ёсны эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, булаан эзлэх гэмт хэрэг зэргийг хамаарах бөгөөд улс тус бүр уг тогтоолд гишүүнээр элсэн орсноор дээрх гэмт хэргүүдийн талаар ОУЭХШ-ийн бүрэн эрхийг автоматаар хүлээн зөвшөөрсөнд тооцдог. Дээрх гэмт хэргүүд дотор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс шилжүүлсэн хэргийн хувьд холбогдох улсын гишүүнээр элссэн эсэхийг харгалзалгүйгээр хэргийг шалгах эрхээ эдлэх боломжтой боловч уг шилжсэн хэргийн талаар болон прокурорын биечлэн хийх шалгалтын талаар хэрэг гарсан орон, эсвэл хэргийн сэжигтэн, гэмт эдгээдийн харьяа улс уг гэрээний гишүүн юмуу эсвэл зөвшөөрөл олгосон тохиолдолд хэргийг шалгадаг.

Мөрдөн байцаах болон хэрэг заалдах

Прокурор хэргийн нэхэмжлэл хүлээн авсан буюу НҮБ-ын Аюулгүйн зөвлөл хэрэг шилжүүлсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаар мөрдөн байцаах үйл ажиллагааг явуулж эхлэх бөгөөд өөрийн шууд эрхийн дагуу хэргийг мөрдөж болно. Хэрэгтэн, хохирогч, гэрчийг байцаан, нотолгоо баримт цуглуулан, шаардлагатай тохиолдолд тухайн улсын туслалцаа эсвэл урьдчилсан шүүхийн хэлтсийн зааварчилгааг авч болох ба хүчээр мөрдөн байцаах эрхээ ч хэрэгжүүлж болдог. Сэжигтэй болох нь тогтоогдвол прокурор нэхэмжлэлийг захиргааны хэлтэст гаргаж өгөх бөгөөд шүүхийн хэлтэс харьяалах эрхийн дагуу зохистой гэж хүлээн зөвшөөрвөл анхан шатны шүүх ажиллагаа эхэлнэ.

Шүүх

Харьяалах эрх болон зохистой чанарын талаар дахин шалгасны дараа сэжигтэй эсэхийг шалгах бөгөөд гэм буруутай эсэхийг нотлох, байцаан шийтгэх зэрэг энгийн хуульзүйн журамтай адил хэрэгжүүлэх ба олон улсын хууль, дотоодын хуультай зөрчилдөх тохиолдолд олон улсын хуулийг тэргүүнд авч үздэг. Нотолгоо, хуульзүйн шийдвэр бүгд шүүгчийн шийдэх асуудал бөгөөд хэргийг шүүх явцад гарсан алдаа, буруу ойлголт, хуулийн алдаа бүгд давж заалдах шалтгаанд тооцогдоно.

II. ОУ-ын хамтын ажиллагаа болон эрүүгийн хуулийн харилцан туслалцаа

Холбогдох улс эрүүгийн хэргийн мөрдөн байцаах журамтай холбогдуулан шүүхтэй хамтарч ажиллах ёстой бөгөөд ялангуяа хэрэгтэнг барих, шилжүүлэх, баримт нотолгоо цуглуулах зэрэгт улс хоорондын хамтын ажиллагаа, хуульзүйн туслалцаа нь шүүх үүргээ гүйцэтгэхэд юунаас ч чухал хэрэгтэй байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

Баривчлэх шийдвэр нь түүнийг гүйцэтгэх санааг илэрхийлсэн улс дотроос шүүхийн зааж тогтоосон улс хэрэгжүүлэх бөгөөд уг улс тодорхойлогдож чадахгүй тохиолдолд шүүхийн байгаа орон үүнийг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ. Үүнд шүүхийн журам дүрмийн дагуу шүүхийн хяналтын доор гүйцэтгэнэ.

III. Прокурор ба прокурорын хэлтсийн хуульзүйн байр суурь

Ерөнхий заалт

ОУЭХШ-ийн тогтоолын 42 дугаар зүйлийн 1 дүгээрт “Прокурор нь шүүхийн биеэ даасан байгууллага бөгөөд бие даан үйл ажиллагаагаа явуулна” гэж заасан бөгөөд прокурорын бие даасан байдлыг тодорхой зааж, уг бие даасан тусгаар байдлыг баталгаажуулахын тулд уг заалтад “Прокурорын хэлтсийн бүрэлдэхүүнд буй ажилтан аливаа гадны байгууллагын заавар тушаалыг авах буюу түүний дагуу ажиллаж үл болно” гэж заасан байдаг. Энэ нь прокурорын хэлтэс, түүний ажилтан нарын бие даасан байдлын талаархи ерөнхий заалт бөгөөд хэргийг мэдүүлэх, заалдах, хэрэг нэхэмжлэх талаар дотоод шалгалт, мөрдөн байцаалт, шүүх, шийдвэр хэрэгжүүлэх бүхий л явцад энэ нь адилхан хэрэгжинэ.

Сонгууль

ОУЭХШ-ийн прокурорыг сонгохдоо ил тод байдал, прокурорын чадавхи болон ёс зүйг чухалчлах нь холбогдох улс орнууд ОУЭХШ болон прокурорын бие даасан тусгаар байдлыг хүлээн зөвшөөрөхөд зайлшгүй хүчин зүйл билээ. ОУЭХШ-ийн тогтоолын 42 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад прокурор, туслах прокурор нь нэгдсэн хуралдаанаас нууц санал хураалтаар дийлэнхи олонхийн саналаар сонгогдоно гэжээ. Прокурорын бие даасан, тусгаар байдал гэдэг талаас авч үзвэл хуучин

Югославын хэргийн шүүх хурал (International Criminal Tribunal for the former Yugoslavia, цаашид Югославын шүүх) болон Руандагийн шүүх (International Criminal Tribunal for Rwanda)-ээс илүү алхам урагшилсан гэж үзэж болох бөгөөд хуучин Югославын хэргийг шүүх хуралдааныг нээх хууль (цаашид Югославын шүүхийн хууль гэж товчлов)-ийн 16 дугаар зүйлийн 4 дүгээр заалт ба Руандагийн хэргийг шүүх хуралдааныг нээх хууль (цаашид Руандагийн шүүхийн хууль гэж товчлов)-ийн 15 дугаар зүйлийн 3 дугаар заалтад нэгэн адил “Прокурор нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын саналаар уг зөвлөлийн хурлаас томилно^{*}” гэж заасан байдаг. Югославын шүүх ба Руандагийн шүүх хоёулаа НҮБ-ын дүрмийн 7 дугаар зүйлд олон улсын энхтайвныг сахин хамгаалах, хүний эрхийг хамгаалахын тулд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тусгай арга хэмжээ авахаар шийдвэр гаргасанд үндэслэн шүүх хуралдах болсон учир анхнаасаа хязгаарлагдмал байсан ба прокурорыг сонгоход ч мөн Аюулгүйн зөвлөлийн эрх мэдэлд үндэслэхээс өөр аргагүй байв. Энэ мэтчилэн Аюулгүйн зөвлөлд түшиглэх нь эцэстээ янз бүрийн улс төрийн ашиг сонирхлоос шалтгаалж Аюулгүйн зөвлөлийн гишүүн орнуудын хооронд прокурор сонгоход санал нэгдэх нь бэрхшээлтэй байсан ба сонгууль 1 жил гаруй хойшлогдох уршигтай болж Югославын шүүх олон улсын улс төрийн наймааны үр дүнд гарсан шүүх гэсэн шүүмжлэлд өртсөн. Тиймээс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс ОУЭХШ прокурор болон туслах прокурорын сонгуульд хөндлөнгөөс оролцохгүй байх санал гарсан нь ч зүй ёсны асуудал буйзаа.

Дахин сонгогдох

ОУ-ын хуулийн хорооны төслийн 12 дугаар зүйлийн 3 дугаар заалтад прокурор, туслах прокурорыг улируулан сонгож болохоор заасан хэдий ч шударга байх ёстой прокурор дахин сонгогдохын тулд аливаа гуйвсан алхам хийж болзошгүйг харгалзан улируулан сонгохыг хориглож, харин оронд нь ОУ-ын хуулийн хорооны төслөөр томилолтын хугацаа 5 жил байсныг сунгах санал хэлэлцэгдэж, томилолтын хугацаа болон улируулан сонгох асуудлаар Зюфэний төслийн 36 дугаар зүйлийн 4-ийн 2-т зааснаар, прокурор, туслах прокурорын томилолтын хугацааг 9 жилээр тогтоон,

^{*} *The tribunal for the former Yugoslavia, S.C.Res.827, UNSCOR, 48th Sess., 3817th mtg, UN Doc.S/RES/827 (1993), Statute of the International Tribunal for the Presecution of persons Responsible for Genocide and Other Serious Violations of International Humanitarian Law Committed in the Territory of Rwanda and Rwanda Citizens Responsible for Genocide and Other Such Violations Committed in the Territory of Neighbouring States, UN SCOR, 49th Sess., 3453rd mtg, UN Doc. S/RES/955 (1994)*

улируулан сонгохыг хориглосон ба ОУЭХШ энэхүү Зюфэний хэргийн төслийг сонгон авч тогтоолынхоо 42 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад прокурор, туслах прокурор аль аль нь 9 жилийн томилолтын хугацаатай ажиллах ба улируулан сонгож үл болно хэмээн заажээ.

Татгалзах ба албан үүргээс чөлөөлөх

Прокурор хувийн болон улсынхаа шалтгаан зэргээс хүлээж авахад зохимжгүй хэргийн тохиолдолд өөрөө саналаараа хэргийг шалгах аас татгалзах, эсвэл албан үүргээс чөлөөлөх нь прокурорын бие даасан байдлыг баталгаажуулахад заавал шаардлагатай асуудал юм. Тиймээс ОУЭХШ тогтоолын 42 дугаар зүйлийн 6 дугаар заалтад “Шүүхийн дарга нарын хэлтсээс прокурор болон туслах прокурорын хүсэлтийн дагуу тэдний онцгой хэргийн хувьд ажил үүргээ гүйцэтгэхээс чөлөөлж болно” гэж заасан ба 42 зүйлийн 7 дугаар заалтад “Прокурор, туслах прокурор нь аливаа нэг шалтгаанаар шударга бусаар хэрэгт оролцох ёсгүй бөгөөд үүний өмнө уг шүүхийн адилхан хэрэг, адилхан хүний хувьд улсын зүгээс холбогдох эрүүгийн хэрэгт оролцсон байх бол тэр хэргээс чөлөөлнө” гэсэн ба 42 дугаар зүйлийн 8 дугаар заалтад давж заалдах шүүхэд прокурор, туслах прокурорын зохистой эсэхийг холбогдох хүний саналаар шийдэх ба энэ нь прокурорын эрхийг буруугаар ашиглахаас сэргийлж байгаа хэрэг юм.

Ажил үүргээс халах

ОУЭХШ-ийн тогтоолын 46 дугаар зүйлийн 2 дугаар заалтад прокурор, туслах прокурор нууц санал хураалтаар дийлэнх олонхийн саналаар ажил үүргээс халагдаж болно. Авилгал, бусад ноцтой хууль бус үйлдэл хийсэн нь нотлогдвол, эсвэл урт хугацаагаар өвчилсөн, ур чадвар доройгоос зохих хэмжээнд үүргээ гүйцэтгэж чадаагүй тохиолдолд ажил үүргээс халж чөлөөлнө. Харин аливаа нэг туслах прокурорын ажлаас чөлөөлөх асуудал хэлэлцэж байх хооронд прокурор, прокурорын хэлтсийн хэлхээ холбоо таслагдах аюулаас сэргийлж, уг туслах прокурорыг ажил үүрэгт түр байлгахыг харгалзаж болдог.

Онцгой эрх ямба болон хөнгөлөлт

ОУЭХШ-ийн тогтоолын 48 дугаар зүйлд зааснаар прокурор, туслах прокурор болон прокурорын хэлтсийн ажилтан нар 1961.4.16-ны Венийн дипломат харилцааны

тухай конвенцийн дагуу тодорхой хэмжээний эрх ямба, хөнгөлөлт эдлэхээр заасан нь эрх чөлөөтэй, бие даасан прокурорын эрхийг хэрэгжүүлэх баталгаа болж байгаа юм.

IV. Мөрдөн байцаалт явуулах журам

Мөрдөн байцаалт явуулах

- Гэрээний гишүүн орнууд

ОУЭХШ-ийн тогтоолын 13, 14 дүгээр зүйлд холбогдох улс уг ОУЭХШ-д хамаарагдах гэмт хэрэг гарсан нөхцөл байдлыг (situation) прокурорт мэдүүлж хэргийг шилжүүлэх талаар заасан байдаг.

- НҮБ-ын Аюулгүйн зөвлөл

“ОУЭХШ байгуулах 1951 оны хорооны төсөл” нь уг ОУЭХШ-ийн гэмт хэрэг шилжүүлэх эрхийг НҮБ-ын Ерөнхий ассамблейд өгсөн ба “1953 оны хорооны төсөл” үүнийг тогтоолоос хасаж оронд нь дэлхийн энхтайвныг сахин хамгаалахын тулд онцгой тохиолдол бий болсон үед НҮБ-ын байгууллага ОУЭХШ-ийн үйл ажиллагааг зогсоож болохоор заасан. Энэ мэтчилэн НҮБ-ын идэвхтэй оролцооны талаар ОУ-ын хуулийн хорооны төсөлд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд гэмт хэрэг шилжүүлэх эрх олгосон. {{Leila Sadat Wexler, The Proposed Permanent International Criminal Court : an Appraisal, 29 Cornell Int'l. L. J. 665, 722 (1996)}} ОУ-ын хуулийн хорооны төслийн 23 дугаар зүйлийн 1-т зааснаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөл асуудлыг түрүүлж авч хэлэлцэх эрхтэй бөгөөд холбогдох улсын зөвшөөрөлгүйгээр ОУЭХШ-ийн хуульзүйн үйл ажиллагааг эхлүүлж болно гэжээ.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл НҮБ-ын дүрмийн 7 дугаар зүйлд үндэслэн олон улсын энхтайвныг сахин хамгаалахын тулд хүчээр арга хэмжээ авах нэг хэлбэрт эрүүгийн хэргийн шүүх хуралдуулах эрх мэдэл өгөгдсөн бөгөөд ОУЭХШ-д гэмт хэргийг шилжүүлж өгөх эрх мэдэл өгөгдсөн нь ч логикийн хувьд зүй ёсны асуудал бөгөөд олонхи орон үүнийг дэмжиж байгаа билээ.

Эцэст нь ОУЭХШ-ийн тогтоолын 13 дугаар зүйлийн 6-д зааснаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөл гэмт хэрэг гарсан нөхцөл шалтгаан (stuation) хэргийг шилжүүлэх эрхтэйг зөвшөөрөхийн хамт 16 дугаар зүйлд дээрх ажиллагааг зогсоох эрхийг хүлээн зөвшөөрч НҮБ-ын дүрмийн 7 дугаар зүйлд зааснаар санал хураах шаардлагатай тохиолдолд 12 сарын турш хэргийг мөрдөн шалгах, нэхэмжлэх асуудал хойшлогдож болох ба үүнийг шинээр өргөн барьж болдог байна.

Прокурор

Югославын болон Руандагийн шүүх хоёулаа прокурорт бие даасан хэргийг мөрдөн шалгах, нэхэмжлэх эрх мэдлийг олгосон. Югославын шүүхийн хуулийн 18 дугаар зүйлийн 1-т болон Руандагийн шүүхийн хуулийн 17 дугаар зүйлийн 1-т нэг адил зааснаар “Прокурор нь засгийн газар, НҮБ-ын байгууллага, олон улсын байгууллага, ЗГ-ын бус олон нийтийн байгууллага, бусад мэдээллийн эх сурвалжуудаас авсан мэдээлэлд үндэслэн бие даан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна” гэж заажээ. Югославын болон Руандагийн шүүхэд прокурор НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон холбогдох улс орнуудаас тусдаа хэргийг мөрдөн шалгах, нэхэмжлэх эсэхээ бие дааж шийдэх болсон байна.

ОУЭХШ хамаарах хэргийн чухал чанар нь Югославын болон Руандагийн шүүхэд хариуцсан хэргээс дутахгүй бөгөөд ОУ-ын хуулийн хорооны төсөлд прокурорт бие даасан хэрэг мөрдөн шалгах эрх мэдлийг олгоогүй байна.

Прокурор бие даан хэргийг мөрдөн шалгаж чадахгүй бол эцэстээ НҮБ-ын Аюулгүйн зөвлөл юмуу холбогдох улс оронд хэргийг шилжүүлж өгөхийг хүлээж, дараа нь хэргийг шалгах байдалд хүргэх ба энэ нь прокурорын бүтээлч амжилттай хэргийг шалгахад нөлөөлж, бусдын эрхэнд ажиллах байгууллага болгон чанарыг доройтуулна. Прокурорын бие даан хэргийг мөрдөн шалгах эрхийн асуудлаар удаан хугацаанд маргасны эцэст ихэнх эрдэмтэд энэхүү эрх мэдэл нь гэрээ хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай гэдэгт санал нэгдэж, Сиракусын төсөл мөн 21 дүгээр зүйлийн 1-т зааснаар прокурорын мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж болох талаар заажээ.

Түүнчлэн Зюфэний төсөлд мөн 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад, прокурор бие даан хэргийг мөрдөн шалгаж, нэхэмжлэх хэргийг шүүхийн хамаарах хэргийн нэг болгон заасан бөгөөд ОУЭХШ-ийн тогтоол эдгээр саналуудыг хүлээн авч 13 дугаар зүйлийн с заалт болон 15 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад прокурор ОУЭХШ-ийн хамаарах гэмт хэргийн талаар мэдээлэлд үндэслэн бие дааж (*proprio motu*) хэргийг мөрдөж болох ба тус шүүхээс прокурорын шалгасан гэмт хэргийн хувьд хэлэлцэх эрхтэйг заажээ.

Прокурорын даасан мөрдөн шалгалт хийх эрх мэдлийг хязгаарлах

ОУЭХШ прокурор бие даасан мөрдөн шалгалт хийх эрх мэдэлтэй байх тохиолдолд тухайн улс буюу Аюулгүйн зөвлөлөөс хэрэг шилжүүлээгүй ч олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө ямар ч хариуцлага хүлээх ухамсаргүйгээр дураараа хэргийг мөрдөн шалгах бол харин ч эсрэгээрээ олон улсын хооронд зөрчил мөргөлдөөнийг энхтайвны замаар шийдвэрлэхэд саад учруулж болзошгүйг үгүйсгэх аргагүй юм. Иймээс энэ талаар хязгаарлах механизм тогтолцоо байх хэрэгтэй юм.

а) НҮБ-ын Аюулгүйн зөвлөл

ОУЭХШ-ийн тогтоол нь Аюулгүйн зөвлөлөөс хамаарч буй хэргийн талаар тус шүүх хамаарах эрхээс татгалзахын зэрэгцээ 16 дугаар зүйлдээ Аюулгүйн зөвлөлөөс хэргийг мөрдөн шалгах, нэхэмжлэлийг түдгэлзүүлэхийг шаардах эрх, хойшлуулах хугацааг өөрчлөхийг шаардах эрх зэргийг олгохоор заасан ба НҮБ-ын Аюулгүйн зөвлөл шаардвал хэргийг шалган нэхэмжлэх нь түдгэлзэх хэмжээнд прокурорын бие даасан мөрдөн шалгах эрх мэдлийг хязгаарлах чухал механизм болж байгааг харуулж байна.

б) Урьдчилсан шүүхийн хэлтэс

1. Хэргийг мөрдөн шалгах зөвшөөрөл олгох

ОУЭХШ-ийн тогтоол нь урьдчилсан шүүхийн үүргийг баримт нотолгоо гаргах үүргээр хязгаарлахгүй мөрдөн байцаах бүхий л үйл ажиллагааны явцад шүүхийн оролцоог хүлээн зөвшөөрч прокурорын монополь эрхийг хязгаарлаж байгаа юм. ОУЭХШ-ийн тогтоолын 15 дугаар зүйлийн 3, 4 дүгээр заалтад, прокурор шууд эрхийн дагуу хэргийг мөрдөн шалгах тохиолдолд урьдчилсан шүүхийн хэлтсээс зөвшөөрөл авах хэрэгтэй бөгөөд хэргийг мөрдөх хангалттай шалтгаан бүхий хэргийн талаар шүүхийн хамаарах асуудалд нийцэж байна гэж үзвэл хэргийг мөрдөн шалгах зөвшөөрөл олгоно. Өөрөөр хэлбэл прокурор төрөл бүрийн арга замаар олж авсан мэдээлэлдээ үндэслэн хэргийг мөрдөн шалгах хангалттай шалтгаан байгаа гэж үзсэн тохиолдолд олж авсан материалын хамт хэргийг мөрдөх зөвшөөрлийн талаар өргөдөл гарган зөвшөөрөл олж авсны дараа шууд эрхийнхээ дагуу хэргийг шалган мөрдөх хэмжээнд уг тогтоол шууд эрх мэдлийг хязгаарласан зүйл болж өгч байгаа юм.

2. Хэрэг нэхэмжлэхийг хянан шалгах нь

ОУЭХШ-ийн тогтоолын 61 дүгээр зүйлд прокурор хэрэг нэхэмжилсний дараа анхан шатны шүүхээр үндсэндээ хэргийг шүүхээс өмнө нэхэмжлэлийг шалган

хянахаар заасан бөгөөд хэрэгтэн гэм буруутайг нотлох үнэмшил бүхий бодит үндэслэл бүхий нотолгоо баримт дутагдалтай байна гэж үзвэл нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох буюу прокурорт нэмэлт баримтжуулалтыг шаардан хэргийг хойшлуулж болдог.

3. Бусад

Прокурор, туслах прокурорын санал нэгдсэн эсэхийг хэргийн мөрдөн шалгах урьдчилсан нөхцөл болгон прокурорын дур мэдсэн шийдвэрийг хязгаарлан, мөн прокурорын үүрэгт ажлаас татгалзах, чөлөөлөх, халах зэрэг тогтоол заалт нь прокурорын бие даасан эрхийг хязгаарлах хөндлөнгийн механизм болж байгаа юм.

4. Хэргийг шалган мөрдөх шийдвэрийн гол шалгуур

ОУЭХШ-ийн тогтоолын 53 дугаар зүйлийн 1-т “Прокурор тус шүүхийн хамаарах асуудлаар гэмт хэрэг гарсныг итгэл үнэмшил төрүүлэхүйц хангалттай шалтгаан бий эсэх, нэмэлт зарчмыг хангасан эсэх, цаашлаад гэмт хэрэг болон хохирогч этгээдийг харьцуулан байцаан шалгах нь шударга ёсыг тогтооход шаардлагатай хэмээн үзэх бодит шалтгаан бий эсэхийг харгалзан хэргийг шалгах хангалттай шалтгаан байна хэмээн үзсэн бол мөрдөлтийг эхлэх бөгөөд прокурорт хэргийг мөрдөхийг зөвшөөрөхгүй байх нь дээрх шударга ёсны талаархи шийдвэрт үндэслэх тохиолдолд прокурор урьдчилсан шүүхийн хэлтэст үүнийг мэдэгдэх ёстой” гэж заасан ба уг зүйлийн 3 дугаар заалтад “Хэргийг шилжүүлсэн тухайн улс, эсвэл Аюулгүйн зөвлөл хүсэлт гаргасан тохиолдолд урьдчилсан шүүхийн хэлтэс прокурорын хэргийг мөрдөхийг зогсоох шийдвэр дээрх шударга ёсны асуудалд үндэслэж байвал шүүхийн хэлтэс бие дааж тус шийдвэр зүй зохистой эсэхийг шалган хэрэв уг шийдвэр шүүхийн хэлтсээс шалгасны дараа хүчин төгөлдөр байна” гэж заасан бөгөөд прокурорын хэргийг мөрдөн шалгах ажлыг эхлэх эсэхийг шийдэх гол шалгуур үзүүлэлт буюу дур мэдэн хэргийг шалган мөрдөхөөс сэргийлэн урьдчилсан шүүхийн журмыг тогтоож өгсөн байна.

V. Дүгнэлт

Дэлхийн олонхи орон ОУЭХШ олон улсын энхтайвныг сахин хамгаалах, хүний эрхийг баталгаажуулахад ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байгаа билээ. Гэвч тус шүүх амжилттай үүргээ биелүүлэхийн тулд үр дүнтэй ажиллаж, ойрын хугацаанд олон улсын хамтын нийгэмлэгийн итгэл, дэмжлэгийг олж авах нь юунаас ч илүү чухал юм. Хэрэв ОУЭХШ цөөн тооны хүчирхэг орнуудын үгээр үйл хэргээ

явуулж, олонхи орны итгэл найдварыг хөсөрдүүлсэн үйл ажиллагаа явуулах буюу тус шүүх өөрөө сул дорой үйл ажиллагаатай байх, холбогдох улс орнуудын туслалцааг олж авч чадахгүй хэргийг мөрдөн шалгах, нэхэмжлэх, шүүх зэрэг хуульзүйн арга хэмжээнд саадтай байгаа нь харагдвал олон улсын дэмжлэгийг алдаад зогсохгүй уг шүүх оршин тогтнох асуудал ч аюултай тулгарч болно.

ОУЭХШ-ийн тогтоол нь хэлэлцээр болж батлагдах хүртлээ олон орны, ялангуяа Англо Саксоны хуулийн орнууд болон эх газрын хуулийн орнуудын хооронд олон удаа хэлэлцээр хийж гаргасан болохоор уг шүүх дээрх хоёр төрлийн хуулийн тогтолцоо онцлогийг хамтад нь багтаасан юм. Гэхдээ өнөөг хүртэл хэлэлцэн тохирсон явц, түүний үр дүнг нэгтгэн авч үзвэл ОУЭХШ нь эх газрын хуулийн мөрдөн шалгах, шүүх тогтолцоог үндсэн хэлбэрээ болгосон гэж хэлж болно. Үндсэндээ ОУЭХШ-ийн тогтоол нь хэргийг шалгах явцтай уялдуулан холбогдох этгээдүүдийн бүтэц бус гэм бурууг голлосон бүтцийг сонгож, иргэдийн төлөөлөгч, шүүгчийг оролцуулсан шүүх бус шүүгчийн удирдсан шүүх хурлыг чухалчилсан бөгөөд цаашлаад бодит үнэнийг шийдэхэд алдаа дутагдал гарсан бол давж заалдахыг ч хүлээн зөвшөөрсөн байгаа юм. ОУЭХШ-ийн бүтэц, тогтолцоо ийнхүү хуульчлан тогтсоны хэрээр түүнд итгэх итгэл үнэмшил, бүтээлч ажлын чадавхи, хэргийг мөрдөн шалгах, шүүх, шийдвэр гүйцэтгэхэд хариуцлага хүлээх прокурорын бие даасан тусгаар байдал, ажлын ур чадвар зэрэг зүйл чухал юм. Мөрдөн шалгах, хэрэг нэхэмжлэхтэй холбогдуулан прокурорын эрх мэдэл аливаа хүчирхэг улс орон, эсвэл олон улсын байгууллагаас хараат байж, түүний эрх ашигт нийцүүлэх хандлагатайгаар буруу ашиглагдах тохиолдолд ОУЭХШ нь тэрхүү хүчирхэг томоохон гүрэн болон олон улсын байгууллагын гар хөл болох тул ОУЭХШ-ийн прокурорын ажил үүрэг аливаа дарамт шахалт, саад болон зохисгүй хөндлөнгийн оролцоо, иргэний хуулийн дагуух хариуцлага зэргээс чөлөөтэй байж үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай билээ.

*Найруулж орчуулсан
Ахлах багш Д.Уламбаяр*

Article follows process of establishment of the International Criminal Court, highlights its international role and significance. Author provides detailed interpretation of the ICC's criminal procedure.